



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/318

Мандалговь

“Дундговь түншлэл-2019” үзэсгэлэн,
худалдаа зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “а”, 30 дугаар зүйлийн 30.1.3, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.2.7, аймгийн үндсэн чиглэлийн 4 дүгээр зүйлийн 4.4.2 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Хүн амын хүнсний болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний хангамжийг дотоодын үйлдвэрлэлээр хангах өргөн боломжийг бүрдүүлэх, дэвшилтэт технологийг нэвтрүүлж стандартын шаардлага хангасан үйлдвэрлэлийн боловсруулах түвшинг ахиулах, харилцан туршлага солилцох түншлэл тогтоох, үйлдвэрлэл үйлчилгээг сурталчлах зорилгоор “Дундговь түншлэл-2019” үзэсгэлэн худалдааг 2019 оны 9 дүгээр сарын 20,21-ний өдрүүдэд “Чагдаржав”-ын талбайд зохион байгуулсугай.

Хоёр. “Дундговь түншлэл-2019” үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав. “Дундговь түншлэл-2019” үзэсгэлэн худалдаанд оролцсон байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг шалгаруулах номинаци, шалгуур үзүүлэлтийг гаргаж, нийт сумд, байгууллага, аж ахуйн нэгж, үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг өргөнөөр оролцуулж, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсэг (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

Дөрөв. Үзэсгэлэн худалдааны шагналд шаардлагатай 2,250,000 (хоёр сая хоёр зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг)-д тус тус зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

48819:917

Аймгийн Засаг даргын 2019 оны 09
дүгээр сарын 11-ны өдрийн 118 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



**“ДУНДГОВЬ ТҮНШЛЭЛ-2019” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн дарга: Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Гишүүд: П.Очирбат (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
О.Мөнхзул (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
Б.Мөнхжаргал (Хүнс, хөдөө, аж ахуйн газрын дарга)
Г.Хишигдаваа (Хөдөлмөр халамжийн үйлчилгээний
газрын дарга)
А.Пүрэвсүрэн (Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн
дарга)
Б.Цэрэнханд (Хүнс, хөдөө аж ахуйн газрын
үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний албаны дарга)
Ж.Мөнхбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын
мэргэжилтэн)
Э.Эрдэнэтунгалаг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын
мэргэжилтэн)
Д.Дэнсмаа (Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн
мэргэжилтэн)
Б.Ням (Худалдаа аж үйлдвэрийн танхимын салбарын
тэргүүн)
Ж.Зоригтбаатар (Ажил олгогч эздийн холбооны
салбарын тэргүүн)

Нарийн бичгийн дарга: Д.Энхтуяа (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 2019 оны 09
дүгээр сарын 11-ны өдрийн 38 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

**“ДУНДГОВЬ ТҮНШЛЭЛ-2019” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНЫ
ШАГНАЛЫН ЗАРДЛЫН ЖАГСААЛТ**

№	Зардлын нэр	Х/нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Зардал хариуцах байгууллага
Засаг даргын нөөц сангаас шагнагдах шагналууд						
1	Шилдэг сүү, сүүн бүтээгдэхүүн	ш	2	150,000	300,000	Засаг даргын нөөц сан
2	Шилдэг газар тариалангийн бүтээгдэхүүн	ш	1	150,000	150,000	Засаг даргын нөөц сан
3	Шилдэг Хүнсний бусад нэрийн бүтээгдэхүүн	ш	2	150,000	300,000	Засаг даргын нөөц сан
4	Шилдэг Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн	ш	2	150,000	300,000	Засаг даргын нөөц сан
5	Шилдэг гар урлалын болон бэлэг дурсгалын бүтээгдэхүүн	ш	1	150,000	150,000	Засаг даргын нөөц сан
6	Шинэ бүтээгдэхүүн, шинийг эрэлхийлэгч аж ахуйн нэгж, иргэн	ш	2	150,000	300,000	Засаг даргын нөөц сан
7	Нийтийн хоолны салбарын шилдэг үйлдвэрлэгч байгууллага	ш	2	150,000	300,000	Засаг даргын нөөц сан
8	Аймгийн брэнд бүтээгдэхүүн	ш	2	150,000	300,000	Засаг даргын нөөц сан
9	Хэрэглэгчдийн таашаалд нийцсэн бүтээгдэхүүн	ш	1	150,000	150,000	Засаг даргын нөөц сан
	ДҮН				2,250,000	